

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ТӨВ НОМЫН САН**



ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

№ 9

2012.12.03

Эмхтгэсэн: Ном зүйч М. Кунай

Ном зүйч Д. Алтанзул

**Электрон каталоги:
<http://catalog.num.edu.mn>**

МАТЕМАТИК, МЕХАНИК



Оюунбилэг Р. **Математик статистик** /Ред. Л.Ажнай. – УБ.: Эрхэс, 2011. -160х.

ЭМШУИС-ийн эрүүл мэндийн технологийн ангид үздэг “Магадлалын онол ба математик статистик” хичээлийн программын дагуу бичигдсэн энэ ном нь санамсаргүй үзэгдэл ба хэмжигдэхүүн., математик статистик, статистик таамаглал, хоёр хэмжээст түүвэр ба регрессийн шинжилгээ, корреляцийн шинжилгээ, хугацааны цуваа гэсэн 7 бүлэгтэй ажээ. Бүлэг бүрт жишээ, бодлого, үзсэнээ бататгах бие даалт-хариуг хавсралт болгон оруулжээ.

22.172

О-63

/БШУН унш-7ш/

Т-15886-15888

Минжүүр Т., Буянтогтох Ж., Нямгэрэл Б. **Онолын механик**: Сурах бичиг. –УБ.: Цогт принт, 2006. -293х.

Техникийн их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн оюутнуудад зориулагдсан энэ номонд онолын механикийн статик, кинематик, динамикийн үндсийг товч, ойлгомжтой байдлаар тайлбарлаж, нэн шаардлагатай жишээ бодлого, тестийг хамтад нь оруулж өгчээ.




22.21

М-57

/БШУН унш-7ш/

Б-22064-22066

ГАЗАР ЗҮЙ, ШУВУУ СУДЛАЛ



Дэлхийн атлас /Орч. Т.Ариунсанаа, Г.Марал, Д.Хүрэлхүү. –УБ.: Нэпко, 2012. -192х.

Хүүхэд залуучууд, оюутнууд энэхүү атласыг судалсанаар эх дэлхийгээ таньж мэдэх юм. Хүрээлэн байгаа байгаль орчин, далай, аж ахуй, шашин, хэл соёл, нөөц баялгийн холбогдолтой газрын зургуудтай бөгөөд дэлхийн 7 тивийг бүлэг болгон танилцуулах ба дэлхийн улсуудын товч танилцуулга, нэр томъёоны толь, дэлхийн тухай зарим тоо баримт, сонирхолтой цахим хаягнууд, газар усны

нэрийн индекс, далайн ёроолын хэлбэрийн индекс зэргийг хавралт болгон оруулж өгчээ.

26.8/0/я6

Д-89

/БШУН унш-7ш/

Т-15901-15903

Жавзан Ч. **Орхон голын сав газрын гидрохими** /Ред. Н.Батсүх, А.Мөнгөнцэцэг. –УБ.: Мөнхийн үсэг, 2011. - 248х.



Энэ номонд манай оронд өрнөсөн гидрохимийн судалгааны түүхийг үечлэн авч үзсэн ба Орхон гол, түүний цутгал голуудын гидрохимийг улирлын горимоор судалж, тухайн голуудын ёроолын хагшаасанд хүнд металлуудын агуулгыг тодорхойлжээ. Түүнчлэн сав газрын газар доорхи ус болон рашааны судалгааны үр дүнг оруулж өгсөн нь энэ районы байгалийн усны химийн найрлага, шинж чанарын судалгаа иж бүрэн хийгдсэнийг харуулж байна. Энэхүү ном нь усны экологи, чанарын талаар судалгаа хийдэг судлаач, оюутан залууст зориулагджээ.

26.22

Ж-10

/БШУН унш-5ш/

Т-15880-15882



Цэвээнмядаг Н., Нямбаяр Б, Мөнхзул Ц. **Монгол орны түгээмэл шувуудыг таних ном.** –УБ.: 2010. -187х.

Энэ номонд монгол оронд элбэг тохиолдох 130, мөн ховордсон 30, нийт 160 зүйл шувуу бүрийн шинж, тархац, амьдрах орчин, үүрлэлт, хоол тэжээл, оршин амьдрах хэлбэр, тоо толгойн байдлын талаар товч бичиглэл оржээ. Мөн шувууны зургийг сууж, нисэж байгаа хэлбэрээр гаргахдаа өнгө зүс, нас хүйс, улирлаар хэрхэн өөрчлөгддөгийг харуулжээ. Шувуу судлаачид, оюутан сурагчид, байгаль хамгаалагч нарт энэ номыг зориулжээ.

28.693.35/1/


Ц-92

/БШУН унш-7ш/

Б-21983-24985

НОГОО, ЖИМСНИЙ ХҮЛЭМЖ

Бат-орших П., Энхбилгүүн Б. **Фермер таны хүлэмж** /Хүлэмж-цуврал №4. –УБ.: Ном хур, 2009. -192х.



Ирээдүйн фермер болон хүлэмжинд ургамал, ногоо тарихыг хүсч буй хүмүүст зориулагдсан энэ номонд хүлэмж барих газраа хэрхэн сонгох, хүлэмж хийх материал, халаалт, усалгаа, гэрэлтүүлэг, цахилгаан монтажны онцлог, агааржуулалт, хүлэмж дарлага барьж байгуулахад шаардагдах багаж хэрэгсэлийн талаар дэлгэрэнгүй өгүүлжээ.

40.8

Б-33

/БШУН унш-7ш/

Б-22067-22069



Бямбажав Н. Сэлэнгэ Б. **Ил талбай, хөлөмж, дарлагад ногоо ургуулах**: Ногоочдын дунд гарын авлага. –УБ.: Жиком пресс, 2010. -323х.

Энэхүү номыг ногоо тарих бодолтой яваа юмуу эхний оролдлогоо хийгээд амт шимтийг амсаж эхэлсэн залуус, энэ ажлын салбарт хүчээ сорьж, үр шимийг нь хүртэж буй дунд, ахмад үеийн ногоочдод зориулжээ. Үүнд ач холбогдол ихтэй голлох ногоо, 10 гаруй зүйл жимс жимсгэнэ, хоол амтлагч амттан ургамлын тухай оруулсан ба хөрс боловсруулах, бордох, тарих, суулгах, арчлах арга, мөн хадгалах боловсруулах, үр авах асуудлуудыг товчхон оруулж өгчээ.

42.34я2

Б-98

/БШУН унш-4ш/

Б-22011-22013

ЭРҮҮЛ АХУЙ

Уянга У. **Жин хасах 6 нууц**. –УБ.: 2012. -182х.

Хоолны дэглэм, олон удаа жингээ хасах гэж оролдсон, дэглэмийн дараа урьдынхаасаа илүү их жин нэмсэн, гуалиг болохыг мөрөөддөг бүх хүмүүст энэ ном зориулагджээ. Ямар ч биеийн ачаалалгүйгээр, хоол хүнсээ хорилгүйгээр, хатуу дэглэм барилгүйгээр



ЭНЭХҮҮ НОМЫГ АШИГЛАН ӨӨРИЙН ХҮССЭН БИЕЙН ЖИН, ГАЛБИРАА ОЛЖ
АВАХЫГ УНШИГЧ ТАНЬД ХҮСЬЕ.

53.51

У-71

/БШУН унш-3ш/

Б-22061-22063

НИЙГЭМ СУДЛАЛ



Бамана Г. **Шударга нийгэм** /Орч. О.Мягмарсүрэн. –
УБ.: Бембисан, 2006. -52х.

Нийгэм судлаач Габи Баманагийн энэ номонд
нийгмийн ойлголт, агуулга багтаамжийг энгийн үгээр
товч тодорхой өгүүлсэн нь бидний нийгэм хийгээд
түүнийг тодорхойлогч хүчин зүйлүүдийн ээдрээ
зөрчил, сул тал нь хаанаа байгааг, мөн эдгээрийг хэрхэн засч
залруулах, зөв залж болохыг танин мэдэхэд ач холбогдолтой
ажээ.

60

Б-22

/НШУН унш-5ш/

Б-22076-22080

Батжаргал Г. **Нийгэм, улс төрийн сэтгэлгээний
онолын асуудлууд: 2-р дэвтэр** /Ред. Б.Галиндэв. –УБ.:
Очир пресс, 2007. -197х.



Энэ номонд нийгэм, улс төрийн сэтгэлгээний онолын
асуудлуудыг хүний тухай философийн ойлголт-
асуудлууд., нийгэм., нийгмийн оюун санааны
амьдрал., соёлын тухай асуудал гэсэн 4 бүлэгт хуваан авч үзжээ.
Мөн орчин үеийн зарим сэтгэгчдийн тухай товч мэдээллийг
хавсралтанд оруулж өгчээ. Энэхүү ном нь улс төр, нийгэм,
философийн чиглэлээр суралцаж буй оюутан залууст гарын
авлага болох ажээ.


60

Б-33

/НХШУН унш-3ш/

Б-22092-22094

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН



Анхтуяа Э. **Их монголчууд ба Таж махал** /Хян. Э. Үүрийнтуяа. –УБ.: Мөнхийн үсэг, 2012. -60х.

1517 онд Энэтхэгийн султан Сикандер Лодиг нас барсны дараа түүний хүү Ибрахим Лоди нь хаан ширээг залгамжилсан боловч 1526 онд Панипатын анхны тулаандаа анхны монгол угсаат хаан Баабарт бут цохигдож, эрх мэдэл болон амь насаа алджээ. Энэ үеэс эхлэн Энэтхэг дэх Их Монголчуудын хаанчлалын суурь тавигджээ. Толилуулан буй энэ номонд Энэтхэг дэх Их Монголчуудын тухай болон 1526-1707 онд хаан ширээнд суусан хүмүүс болоод дэлхийд алдартай Таж Махалын тухай өгүүлнэ.


63.3/5Энэт/лб

А-66

Т-15871-15873

Баярхүү Д. **Би: Миний амьдралын тойрог.** –УБ.: Нэпко, 2009. -546х.

Профессор Д.Баярхүү өөрийн туулж өнгөрүүлсэн амьдрал, намтар, ГХЯ болон Каир, Эль Кувейтэд элчин сайдаар ажилласан тухай дурсамж номоо уншигчдад толилуулж байна. Монголын нийгэмд харанга дэлдсэн нийтлэлүүдээрээ нэгэнт уншигчдын танил болсон Д.Баярхүүгийн энэ номыг уншсанаар Монгол орны хөгжлийн түүхэн шилжилтийн цаг үеийн нийгмийн талаар үнэн мэдээлэл авах ажээ.




63.3/1/-8

Б-38

/НХШУН унш-3ш/

Б-21971-21972



Бедарида Ф. **Чорчилл** /Орч. Ц.Гомбосүрэн. –УБ.: Нэпко, 2012. -516х.

Цэрэг, сэтгүүлч, депутат, улстөрч, зохиолч, зураач, түүхч, уран илтгэгч, төрийн зүтгэлтэн, Английг жолоодож байсан язгууртны сүүлчийнх нь асан – энэ бол 90 насалсан Винстон Чорчилл юм. Их Британийн

бахархалт бэлгэдэл болсон Винстон Черчиллийн намтар, амьдрал, ажил үйлс, үйл ажиллагааны тухай энэ номонд дэлгэрэнгүйгээр өгүүлжээ.


63.3/4Анг/-8

Б-39

/НХШУН унш-3ш/

Б-21996-21997

Болбаатар Ч. **Монгол улс 100 жил**: Он дарааллын бичиг /1911.12.29-2011.12.29/ -УБ.: Нэпко, 2012. - 253х.



Бидний туулж өнгөрүүлсэн нэгэн зууны он дарааллын энэхүү бичигт Монголын түүхийг өдөр сараар дараалуулан оруулжээ. Үүнд 1911 оны 1-р сараас эхлүүлж, түүнийхээ 100 жилийн ойг төрийн баяр болгон тэмдэглэсэн 2011 оноор өндөрлөжээ. Зуун жилийг арав, арваар багцалж, жил тус бүр дээр календарь үйлдэн тухайн жил, сар, өдөрт болсон онцлог үйл явдлыг хураангуйлан оруулжээ. Мөн түүнчлэн тухай үед гадаад ертөнцөд өрнөж байсан үйл явдлыг ч бас товчлон оруулжээ.

63.3/1/

Б-57

/НХШУН унш-7ш/

Т-15907-15909



Мягмарсамбуу Г. **Монгол улсын цэрэг, цэргийн жанжид**: ХХ зууны эхэн. 2,3,4-р боть. –УБ.: 2011-2012.

БХ-ын эрдэм шинжилгээний хүрээлэн, Монголын цэргийн түүхчдийн “Хар сүлд” холбооноос эрхлэн гаргаж буй “Монгол улсын цэрэг, цэргийн жанжид” цуврал номын 2,3,4-р ботийг уншигчидда толилуулж байна. Энэхүү цуврал номын 2-р ботид Ялгуун баатар Лаварын Сумьяа ба түүний цэрэг эрсийн амьдрал, тэмцэл хувь заяа., 3-р ботид Төр цэргийн нэрт зүтгэлтэн, домогт жанжин ардын Хатанбаатар С.Магсаржав., 4-р ботид Цэргийн жанжин Манлай баатар Жамсрангийн Дамдинсүрэнгийн амьдрал, үйл ажиллагаатай холбогдолтой материалууд тус тус оржээ.

63.3/1/6

2-р боть: Л Сумьяа. -419х.

Т-15935-15937

М-69

3-р боть: С.Магсаржав. -390х.

Т-15938-15940

4-р боть: Ж.Дамдинсүрэн. -322х.

Т-15941-15943

Наранцэцэг Д., Долгорсүрэн Д. **Үзэмчний түүх соёлын ойллого** /Ред. П.Алтангэрэл. –УБ.: 2011. - 288х.




Монгол улсад амьдарч байгаа үзэмчин ястны түүх, угсаа гарвал, эдийн болоод оюуны соёл, аман бичгийн зохиол, ардын уламжлалт зан үйлийн талаар энэ номонд өгүүлжээ. Үзэмчингүүд Алтай, Хангайн завсарт үзмийн цагаан ууланд нутаглаж байсан түүхтэй ажээ. Эх түүхээ сонирхон судалж буй бүх уншигчдад энэхүү номыг зориулжээ.

63.5/1/

Н-29

Б-22095



Ядамсүрэн Ү. **Монголын хуучны зэрэг дэвийн хувцас**: Альбом. –УБ.: Адмон, 2010. -138х.

Төрийн шагналт, ардын зураач Ү.Ядамсүрэн /1905-1986/ нь 1940-өөд оноос бүтээлээ туурвиж эхэлжээ.

Алдарт зураач толилуулан буй энэхүү номоо 1975 онд хэвлүүлэхээр өгсөн боловч ямар нэг шалтгаанаар хэвлэгдэлгүй өдий хүрчээ. Энэхүү өнгөт зурагтай номонд нийт 105 төрлийн зураг орсон бөгөөд зургийн тайлбарыг монгол, англи хэл дээр хийжээ.

63.5/1/я6

Я-32

/НХШУН унш-3ш/

Т-15898-15900

ЭДИЙН ЗАСАГ

Аюурзана Ц. **Компанийн санхүү** /Хян. Ц.Сүхбаатар. –УБ.: Соёмбо принтинг, 2010. -267х.

Зохиогчийн урьд өмнө бичсэн “Аж ахуйн нэгжийн санхүү /2002/”, “Хөрөнгө оруулалт: Бодлого эрх зүйн зохицуулалт, төлөвлөлт, санхүүжилт /2005/”, “Санхүүгий менежмент /2007/” зэрэг номын үргэлжлэл болох энэ номонд компанийн санхүү түүний үүргүүд, зохион байгуулалт, зорилго ба орчин, санхүүжилтийн арга эх үүсвэрүүд, компанийн зардал, орлого, ашиг, эргэлтийн хөрөнгийн бүрдэлт, ашиглалт, хөрөнгө оруулалт түүний санхүүжилт, санхүүгийн төлөвлөлт мөн жижиг дунд үйлдвэрийн санхүүгийн онцлог зэрэг асуудлуудыг




дэлгэрэнгүй авч үзжээ. Энэхүү ном нь их дээд сургуулийн санхүүгийн чиглэлээр суралцаж буй оюутан, магистрант, докторантууд болон аж ахуйн нэгж, санхүүгийн байгууллагад ажиллаж байгаа санхүүч нарт зориулагджээ.

65.290-93

А-96

/НХШУН унш-5ш/

Т-15866-15870



Батхүрэл Г., Дорж Т. **Монголын менежментийн сэтгэлгээний хөгжилт** /Ред. Б.Энхтүвшин. –УБ.: Наранбулаг принтинг, 2011. -386х.

Зохиогчид энэ номондоо “Монголын менежментийн сэтгэлгээний хөгжил”-ийг “Менежментийн сэтгэлгээний хөгжил, түүний хандлага”, “Нүүдлийн соёл иргэншлийн үеийн монголын менежментийн сэтгэлгээ /МЭӨ III-МЭ XX зуун/”, “Хосолмол соёл иргэншлийн үеийн Монголын менежментийн сэтгэлгээ хөгжиж ирсэн чиг хандлага, өв уламжлал”, “XXI зууны үеийн Монголын менежментийн хөгжлийн үзэл баримтлал, загвар боловсруулах арга зүй” гэсэн 4 бүлэгт хуваан авч үзжээ.

65.290-2

Б-34

/НХШУН унш-7ш/

Т-15932-15934

Вэлентайн Ж.Л. **MLM-ийн хүч буюу амьдралаас хүссэн бүхнээ олж авах нь.** –УБ.: 2009. -299х.

Жеймс Ли Вэлентайн энэхүү бүтээлээрээ сүлжээний маркетингийн мэргэжилтнүүдийг түвшин ахиж их амжилт гаргахад нь урам зориг дэм өгөх зорилготой бөгөөд сүлжээний маркетингийн мэргэжилтнүүд амьдралаа эерэгээр өөрчлөн, санхүүгийн хувьд хэнээс ч хараат бус болж бүрэн дүүрэн амьдралаар амьдрах аргачлалуудыг санал болгож байна.

65.290-2

В-97

Б-22057-22060



Ганзориг А., Ундармаа Б., Батбаяр Т. **Банк, санхүүгийн үг хэллэгийн тайлбар толь:** Англи,

орос, монгол хэлээр. –УБ.: Мөнхийн үсэг, 2012. -229х.

Гурван хэлний энэхүү тайлбар тольд банк, санхүүгийн салбарын ажил, үйлчилгээнд түгээмэл хэрэглэгддэг 3590 гаруй нэр томъёо, нийлэмж үгийг багтаажээ. Энэхүү тайлбар толь нь банк, санхүү, эдийн засгийн мэргэжилтэн, судлаач, багш, оюутнуудад энэ чиглэлээр хэлний мэдлэгээ дээшлүүлэхэд гарын авлага-ширээний ном болох ажээ.

65я2

Г-22 /НХШУН унш15ш/

Б-22006-22010

Дочинхүү Ц., Буянбадрах М. **Хувьцаа сонирхогчийн ширээний ном: Бүрэн хэмжээний гарын авлага.** –УБ.: Экимто, 2012. -336х.




Энэхүү бүтээлд дэлхий дахинд бүх хүмүүс өөрийн амьдралдаа хэрэглэж дадсан, хувьцаа хэмээх гайхамшигтай зүйлд хөрөнгө оруулж, мөнгө хийдэг үнэт цаасны зах зээлийн талаар өгүүлэх ба хувьцаанд хөрөнгө оруулах сонирхолтой, өөрийн ажил амьдралдаа ашиглаж хэрэглэх хүсэлтэй хүмүүс, оюутан залуус, ажилтан, албан хаагч, эмч, багш, төрийн албан хаагч болон нийт хувьцаа сонирхогч уншигчдад зориулагджээ.

65.262.2я2

Д-57 /НХШУН унш-5ш/

Б-22001-22005



Дракер П.Ф. **XXI зууны менежментийн үүрэг ба сорилт** /Орч. А.Батсайхан, С.Цэрэндамба. –УБ.: Оргилпресс, 2012. -220х.

АНУ-ын нэрт эрдэмтэн асан Питер Ф. Дракер нь менежментийн олон бүтээлийн зохиогч гэдгээрээ төдийгүй улс төр, эдийн засаг, нийгмийн асуудалд зориулсан аналитик зохиол нийтлэлээрээ алдартай. Дракерийн бүтээлүүд дэлхийн 40 гаруй орны хэл дээр орчуулагдан хэвлэгдэж, төр засгийн болон, бүх шатны удирдагч, эрдэмтэн судлаач, оюутан залуусын ширээний ном, ажил албаны дотны зөвлөх болсоор байна. Түүний энэ номонд шинэ зуунд оюуны хөдөлмөрийн ажилтнуудын бүтээмж гол хүчин зүйл болох тухай, мөн хөдөлмөрийн энэхүү бүтээмж юугаар тодорхойлогдох

болсон, түүнийг хэрхэн дээшлүүлэх, оюуны хөдөлмөрийн ажилтнуудыг хэрхэн удирдах, албан тушаал дэвшихэд менежментийн арга туршлагыг яаж ашиглах зэрэг олон асуудалд хариулт өгөх ажээ.

65.290-2

Д-61

Б-21965-21968

Монголын баячуудын нууцаас /Эмх. Т.Аригбөх. – УБ.: 2008. -145х.



Батж.Батбаяр, Лу.Болд, С.Болдхэт, Б.Жаргалсайхан, С.Мянганбаяр, Ж.Оджаргал, М.Сономпил, У.Уламбаяр, А.Шагдарсүрэн, Б.Эрдэнэбат зэрэг монголын бизнесийн ертөнцийн 30 төлөөлөгч монголын нөхцөлд, монгол сэтгэлгээг хэрхэн дайчлан баяжсан талаарх үнэн түүхийг энэ номонд өгүүлжээ. Уншигч та энэ номыг уншсанаар чинээлэг хангалуун амьдралд хүрэх ухааныг ойлгож, бодит байдалд хэрэгжүүлэх энерги эрч хүчээр цэнэглэгдэх болно.

65

М-69

Б-22029-22031



Нарандэлгэр Д. Эдийн засгийн синергетик. –УБ.: Урлах эрдэм, 2012. -133х.

Шинжлэх ухаан өндөр хөгжсөн орнуудад удирдлагын дээд болон дунд төвшинд шийдвэр гаргах, бодлого боловсруулах, улс орны хөгжлийн хэтийн төлөвийг загварчлах, байгаль орчныг хамгаалах зэрэг асуудалд синергетикийн шинжлэх ухааны арга загваруудыг өргөн хэрэглэх болжээ. Толилуулан буй энэ номонд синергетик нь эдийн засгийн ухааны судалгааны арга хэрэгсэл болох тухай, энгийн дифференциал тэгшитгэлийн онолыг хэрхэн хэрэглэх, нийгэм эдийн-засгийн системийн загварчлалын тухай өгүүлжээ.

65в6

Н-29

Б-21961-21964

Наранцэцэг П. Хүний нөөцийн менежмент /Хян. Т.Дорж. –УБ.: ВСІ, 2009. -180х.



Энэхүү бүтээл нь төр, бизнесийн болон иргэний нийгмийн байгууллагуудын бүх түвшний удирдлагууд, хүний нөөцийн менежер болон мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач, докторант, магистрант, оюутан сурагчдад зориулагджээ. Онол арга зүй болон кейс дасгал гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэх энэхүү номонд хүний нөөцийн менежментийн үндсэн асуудлууд, ажлын бүтцийн шинжилгээ, хүний нөөцийн төлөвлөлт, ажилтныг шилж сонгох, чиглүүлэх сургалт, байгууллагын менежментийг хөгжүүлэх, ажиллагсадын гүйцэтгэлийг үнэлэх, байгууллагын урамшууллын систем, олон улсын бизнесийн хүний нөөцийн менежмент ба ёс зүй, байгууллага дахь зөрөлдөөнт байдал ба албан бус хэсгийг удирдах зэрэг асуудлуудыг тусгажээ.

65.290-2

Н-29

Б-22089-22091



Одмаа Д. **Амжилтанд хөтлөх маркетингийн төлөвлөгөө боловсруулах ур ухаан.** –УБ.: Адмон, 2006. -74х.

Маркетингийн гол зорилго нь хэрэглэгч юу хүсэж байгааг олж тодорхойлоод түүнийг нь хангахад оршдог. Маркетингийн төлөвлөгөө боловсруулах тухай өгүүлэх энэ номонд төлөвлөлтийг юунаас эхлэх, маркетингийн аудит хийх, маркетингийн зорилгуудаа хэрхэн тодорхойлох, маркетингийн стратеги боловсруулах зэрэг асуудлуудыг авч үзжээ.

65.290-2

О-19

Б-22109

Траут Ж., Райс Э. **Маркетингийн дайн** /Орч. Г.Пүрэвсамбуу., Хян. О.Чинбаяр. –УБ.: Номт пресс, 2012. -259х.

Энэ ном бол хэрхэн зөв стратегийг баримтлах тухай өгүүлсэн бүтээл ажээ. Танай компани том, жижиг эсвэл дунд зэргийн байх нь хамаагүй. “Маркетингийн дайн” хэмээх энэ номыг цаашид үргэлжлүүлэн уншиж судлах нь XXI зуунд тэсч үлдэх, хэв загвараа олж тогтооход тань тус болох ажээ. Компаниуд өөр хоорондоо өрсөлдөж сурах, нэг нэгнийхээ



сүр хүчтэй талаас нь зайлсхийх, харин сул талыг ашиглахад суралцах хэрэгтэй...

65.290-2

T-61

/НХШУН унш-7ш/

Б-22026-22028



Цэнд-аюуш Т. **Компанийн засаглал** /Ред. Р.Амаржаргал. –УБ.: Бит пресс, 2011. -328х.

Компанийн засаглалын үндсэн гол асуудлуудыг багтаасан энэ ном нь компанийн сайн засаглал гэдгийг хэрхэн бий болгож, олон улсын зах зээл дээрээс хөрөнгө татах вэ хэмээн зорьж яваа бизнесийн хүмүүст гарын авлага болоод зогсохгүй энэ чиглэлээр суралцаж буй оюутан залууст сурах бичиг болох агуулгын өргөн багтаамжтай ажээ. Энэ номонд орсон тайлбар болон жишээ, кейсүүд нь АНУ-ын компанийн засаглалын тогтолцоо, тоо мэдээн дээр үндэслэгджээ. Учир нь өнөөгийн байдлаар дэлхийн хөрөнгө оруулалтын капиталын ихэнхийг эргэлдүүлж байдаг, хувьцаа эзэмшигчдийн итгэл найдварыг өнөөгийн байдлаар хамгийн өндөр түвшинд хамгаалж байгаа тэргүүний туршлагыг уншигчдад өгөхийг хүсчээ.

65.290-2

Ц-95

Б-22023-22025

УЛС ТӨР СУДЛАЛ

Ардчилал, иргэний засаглал. –УБ.: Китаб, 2012. - 204х.

“Иргэний засаглал ба ардчилсан парламентат ёс”, “төрийн тогтолцооны шинэтгэл” хэмээх 2 бүлэгтэй энэ номонд нутгийн өөрийн удирдлага болон нийгмийн харилцааны тогтолцооны талаар өгүүлэх ба нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн актууд, зарим улс орнуудын үндсэн хуулийн заалтуудаас эмхэтгэн хавсаргажээ.

66.3/1/12

A-72

Б-21949-21951





Бро Ф. **Улс төр судлал** /Орч. Ч.Баатар. –УБ.: Хөх судар принт, 2010. -124х.

Францын улс төр судлаач Филип Брогийн “Улс төр судлал” бүтээл нь улс төрийн шинжлэх ухааны суурь бүтээлүүдийн тоонд ордог бөгөөд энэхүү ном нь оюутаан сурагч, сонсогч, магистрант, докторант зэрэг улс төрийн чиглэлээр судалгаа хийж буй хүмүүст онол, аргазүйн чухал хэрэглэгдэхүүн болох ажээ. Энэ номонд улс төрийн суурь ойголтуудыг улс төр үүсэх хүчин зүйлүүд, улс төр судлалын хамрах хүрээ, тавигдаж буй асуудал ба урсгал чиглэлүүд гэсэн 3 хэсэг, 9 бүлэгт хуваан авч үзжээ.

66.0

Б-68

/НХШУН унш-12ш/

Б-22081-22085

Төр улсуудын засгийн газар: Дэлхийн улс төрийн тогтолцооны гарын авлага /Орч. Ч.Долгорсүрэн, Г.Билгээ. –УБ.: Монсудар, 2012. -320х.



Энэхүү номны 1-р бүлэгт МЭӨ 8000 жилийн тэртээгээс өнөөдрийг хүртэл үүсэж бий болсон засаглал, түүнтэй холбоотой улс төрийн шинжлэх ухааны бусад ойголт, ухагдахууны гарал үүслийг засаглалын хэлбэрүүд үүссэн он цагийн дарааллын дагуу зургаар товч тайлбарласан ба 2-р бүлэгт дэлхийн аль ч улс орны улс төрийн байдалд нөлөөлж, заримдаа тодорхойлж байдаг олон улсын сүлжээ, бйагууллагуудын үүсэл, хөгжлийн ерөнхий дүр зургийг харуулжээ. 3-р бүлэгт засаглалын тогтолцоо буюу улс орнуудад тогтон хэрэгжиж буй засаглалын үндсэн 6 тогтолцоог нийт 193 орны жишээн дээр тайлбарлажээ.

66.3/0/12

Т-59

/НХШУН унш-3ш/

Т-15904-15906

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА



Батчимэг М. **Шатрын өрөг дэх Монгол:** Олон улсын улс төр /Ред. О.Машбат. –УБ.: Мөнхийн үсэг, 2012. -311х.

Судлаач М.Батчимэг сүүлийн жилүүдэд хийсэн судалгааны бүтээлүүдээ эмхтгэн толилуулж байна. Энэ

номонд үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын талаар, ялангуяа БНХАУ-тай харилцах бодлого, чиглэлийг өнөөгийн шинэ нөхцөлд тодотгон залах шаардлагатай болсон гэдэг шинэлэг үндэслэлийг дэвшүүлжээ. Олон улсын аюулгүй байдлыг ойлгох, өргөн хэмжээнд сэтгэж, үйлдэхийг хүсдэг хүн бүхэнд энэ ном зориулагджээ.

66.4/1/

Б-34

/НХШУН унш-10ш/

Б-21977-21982

Баярхүү Д. **Тахрирын хувьсгал.** –УБ.: Нэпко, 2011. - 534х.



Профессор Д.Баярхүүгийн энэ ном бол түүний АБНЕУ-д элчин сайдаар ажиллаж байхдаа, дипломатчийн өдрийн тэмдэглэл хэлбэрээр бичсэн түүхэн зохиол ажээ. Энэ номонд Египет оронд 2011 онд өрнөсөн, өрнөх нь бүү хэл донсолгосон, улмаар Египетээр дамжаад нийт ойрхи Дорнодын бүс нутагт хүчтэй нөлөөлсөн “Тахрирын хувьсгал”-ын тухай өгүүлнэ.

66.49

Б-38

/НХШУН унш-3ш/

Б-21969-21970

Жамбалдорж Д. **Монгол улс ба гадаад улс, гүрнүүдийн хоорондын харилцаа, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны үүсэл, хөгжлийн түүхэн он жилүүд:** ОХУ, БНХАУ, АНУ, Их Британи, Япон, Герман, Франц, Канад, БНСУ, Чех, Унгар, Польш, Болгар, Румын /Ред. Ж.Гөлгөө. –УБ.: Адмон, 2012. -186х.



Энэ номонд Монгол улс ба ОХУ, БНХАУ, АНУ, Их Британи, Япон, Герман, Франц, Канад, БНСУ, Чех, Унгар, Польш, Болгар, Румын улс хоорондын харилцаа, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны үүсэл, хөгжлийн түүхийг Богд эзэн хаант Монгол улсын түүхээс эхлэн 2012 он хүртэлх хугацааг хамруулан судалжээ. Монгол улсын гадаад бодлого, дипломат харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар цэгцтэй ойлгоц өгөх тул оюутан, магистрант, докторант нарт гарын авлага болох ажээ.

66.4/1/

Ж-23

/НХШУН унш-3ш/

Б-22106-22108



Сандаг Ю. **Дипломат баримт бичиг, тэдгээрийн түгээмэл хэлбэр** /Хян. Д.Ёндон. –УБ.: Ган принт, 2011. -179х.

Гадаад харилцааны ажил эрхэлж буй хүмүүс болон оюутан залуучуудад дипломат баримт бичгийг монгол, франц, орос, англи хэлээр боловсруулж сурахад гарын авлага болох энэ номонд дипломат баримт бичгийн төрөл зүйл, олон талт хэлэлцээ, зөвшөөрөл хүсэх баримт бичиг, итгэмжлэх жуух бичиг, орчин үеийн дипломат хэлний онцлог шинж, өргөн хэрэглэгддэг үг, хэллэгийн тухай дэлгэрэнгүй өгүүлсэн ба мөн зарим дипломат баримт бичгийн загвар, баримт бичиг хөтлөх стандарт жишээг хавсралт болгон оруулжээ.

66.49

С-29

/НХШУН унш3ш/

Т-15892-15894

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

БНХАУ-ын дээд шүүхийн иргэний эрхэд холбогдох зарим тогтоолууд /Хөрв.эмх. Т.Мөнхжаргал, Б.Батбаяр. –УБ.: 2012. -88х.

Энэ номонд БНХАУ-ын Ардын Дээд Шүүх хорооны “БНХАУ-ын ургийн хууль”, хүний биеийн хохирлыг төлөх, иргэний хэргийг хялбарчилсан журмаар шийдэх, нэр хүндийн эрхэнд халдсан хэрэг, иргэний заргын гэрч баримтын тухай тохируулан хэрэглэх асуудлуудын тухай тайлбарууд мөн тогтоолууд, иргэний хэргийг гүйцэтгэх явц дахь байцаан битүүмжлэх, барьж үлдэх, үл хөдөлгүүлэх эд хөрөнгийн тухай тогтоолууд тус тус оржээ. Энэ ном нь хууль боловсруулагчид, оюутан, магистрант, докторантууд БНХАУ-ын хууль дүрмээс санаа, загвар авах, харьцуулан үзэхэд үнэтэй гарын авлага болох ажээ.

67.410/5Хят/

Б- 81

/НХШУН унш-3ш/

Б-22104-22105





Гадаад харилцаа: Эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. 2 дахь хэвлэл /Эмх. А.Төмөр, А.Түвшинтулга. –УБ.: ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр, 2012. -528х.

Анх 2004 онд хэвлэгдсэнээс хойшхи хугацаанд уг номонд орсон хууль тогтоомжийн нилээд нь шинэчлэгдэн өөрчлөгдсөн ажээ. Иймд төрийн захиргааны байгууллагын ажилтан, шүүгч, өмгөөлөгч, прокурор, мөрдөн байцаагч, нотариатч, хуулийн зөвлөх, оюутан залуус болон нийт иргэдэд зориулан Монгол улсын гадаад харилцаанд холбогдох шинэчлэгдсэн хууль тогтоомжуудыг түүвэрлэн энэ номонд оруулжээ.

67.412.1

Г-13

T-15874-15875

Консулын эрх зүй: Баримт бичиг. Гарын авлага /Хян. Ж.Амарсанаа ба бус. –УБ.: ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр, 2012. -446х.

Хоёр дахь удаагаа хэвлэгдэн гарч буй энэхүү гарын авлага нь төрийн захиргааны байгууллагын ажилтан, шүүгч, өмгөөлөгч, прокурор, мөрдөн байцаагч, нотариатч, хуулийн зөвлөх, оюутан залуус болон нийт иргэдэд зориулагдсан бөгөөд энэ номонд Монгол улсад оршин суухтай холбогдсон Монгол улсын хууль тогтоомж болох олон улсын олон талт гэрээ, монгол улс гадаад улс хоорондын байгуулсан хоёр талт консулын конвенц, монгол улс гадаад улсын иргэдийн харилцан зорчих нөхцлийн тухай хэлэлцээрүүдийг түүвэрлэн оруулжээ.

67.412.1я2

К-65

T-15915-15918



Ли Ён Юл, Андерсон Ч. **Бодлогын шинжилгээ** /Орч. А.Цанжид. –УБ.: 2010. -224х.

Бодлогын шинжилгээ бол дипломын дараах сургалтанд байнга ордог хичээл ажээ. Энэхүү сурах бичиг нь төрийн захиргааны чиглэлээр суралцаж буй бакалаврын түвшний оюутнуудад зориулагдсан хэдий ч бодлогын шинжилгээ түүний мөн чанар, мэдээлэл ба

хувилбарууд, үнэлгээний шалгуур, өртөг-үр өгөөжийн шинжилгээ, эрсдлийн үнэлгээ, шийдвэрийн шинжилгээ ба асуудлууд, үнэлэлт өгөх зэрэг асуудлыг сонирхдог төрийн алба хашиж буй хүмүүст ч гарын авлага болох ажээ.

67.401я73

Л-54

Б-22072-22073

Монгол улс дахь олон улсын эрх зүйн хөгжлийн чиг хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. –УБ.: ТЕГ-ын хэвлэх, 2012. -182х.



МУИС-ийн ОУХС, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Үндэсний тагнуулын академиас санаачлан энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулжээ. Энэ хурлаар олон улсын эрх зүй, Монгол улсын гадаад харилцаа, олон улсын түгээмэл эрх зүй, олон улсын аюулгүй байдал, хүний эрхийг хамгаалах олон улсын хамтын ажиллагаа, хоёрдмол харъяалал, гэмт хэрэгтэй тэмцэхэд олон улсын гэрээ конвенцийг хэрэгжүүлэх, энхийг дэмжих ажиллагаа, олон улсын эдийн засгийн эрх зүй, монголын гадаадын хөрөнгө оруулалт, цахим худалдаа, генетикийн талаарх эрх зүйн зохицуулалттай холбогдолтой илтгэлүүдийг авч хэлэлцжээ.

67.412.1

М-69

Т-15889-15891



Нямсүрэн Ч. Эрх зүйн ерөнхий онол: Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал /Ред. Б.Батэрдэнэ. –УБ.: Соёмбо принтинг, 2010. -464х.

Хууль зүйн шинжлэх ухааны онолын ойлголт., эрх зүйн ухамсар., эрх зүйн хэлбэр., эрх зүйн харилцаа., хүн төрлөхтний нийтлэг глобал асуудал ба эрх зүй хэмээх 4 хэсэг 31 бүлгээс бүрдэх энэхүү бүтээл нь зохиогчийн 1995, 1997, 2001, 2004 онд хэвлэгдсэн эрх зүй, төрийн ерөнхий онолын сурах бичгүүдийн үргэлжлэл боловч англо-саксоны болон роман-германы эрх зүйн улс орнуудын эрдэмтэн мэргэдийн бүтээлүүдийн шинэ мэдээллээр ихээхэн баяжуулжээ.

67.0

СУДАЛГААНЫ АРГА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

Гангантогос-Өлзийбаясгалан Ю. **Эрдэм шинжилгээ, судалгааны ерөнхий аргачлал** /Хян. Я.Юндэн. –УБ.: Шидэт өнгө, 2010. -352х.




Залуу судлаачдад эрдэм-шинжилгээ судалгааны ажлыг хэрхэн хийж эхлэх, дуусгах мөн яаж бичгийн хэлбэрт оруулах, хамгаалахтай холбогдсон аргачлал, арга зүйг хөндсөн олон асуудлууд тулгардаг. Толилуулан буй энэхүү аргачлалд тэрхүү бэрхшээлийг хэрхэн даван туулах, эрдэм шинжилгээний ажил /өгүүлэл, реферат, эрдэм шинжилгээний ажлын тайлан/ туурвихдаа ямар дараалал логиктой ажиллах, асуудлыг хэрхэн дэвшүүлэн тавих, хамгаалах мөн тэдгээртэй холбогдолтой дүрэм журмын талаар энэ номонд өгүүлэх ажээ.

72

Г-21

Б-21986-21987



Эрдэм шинжилгээний бичиг: Түүх-Х, XI: № 267, 373 /МУИС, НШУС. –УБ.: 2011-2012.

МУИС-ийн НШУС-иас эрхлэн гаргасан “Түүх”-ийн эрдэм шинжилгээний бичгийн № 267 дугаарт Цавчаалын уулзалт, Зүүнгар дахь Чингийн аян дайн, 1767 он Олхуны харуулын хэрэг, “Улаалзайн хэрэг”, Дарьгангын тэргүүн нарын зөрчил, Чин сүжигт номун хан, Бөө мөргөл, Янпай, БНМАУ-ын баатар цол, цахар ӨлзийБадрах., № 373 дугаарт цэргийн нэр томъёо, Дархадын Гэлэг ноён хутагт, Хуучин баргын үүсэл, Хятад цэргийн дэглэм, Хүрээ Консулын дэнж, Нийслэл хотын захиргаа баригдсан нь, дэлхийн цаг уурын дулаарал, Эрдэнэ Шанзудба нарын тухай судалгааны өгүүллүүд тус тус оржээ.

72

Э-73

/НХШУН унш-1, Лав-1ш/

№ 267. -326х.

Т-15925

№ 373. -212х.

Т-15926

БОЛОВСРОЛ СУДЛАЛ

Батхуяг С. **Амжилттай суралцах арга зам: Хэрхэн амжилттай суралцах вэ?** –УБ.: Содпресс, 2012. -48х.



Их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан энэ номонд оюутан болохын утга учир, шинжлэх ухаанд суралцахын онцлог, лекц сонсож тэмдэглэх болон түүнтэйгээ ажиллах арга барил, ном хэвлэлтэй ажиллах арга ухаан, лаборатори дадлагын хичээлд бэлтгэх, бодлого бодох, эссэ бичих, багштайгаа харьцах ухаан, дадлага, гадаад хэл сурахын ач холбогдол, реферат, курсын ажил гэж юу болох хэрхэн бичих тухай өгүүлнэ.

74.58я7

Б-34

/НХШУН унш-4ш/

Б-22020-22022



Боловсролын менежмент. –УБ.: 2006, 2008.

“Боловсролын менежмент” сэтгүүлийн 2006 оны №1-д хүний хөгжил, боловсролын тогтолцоо, төрийн боловсролын бодлого, сургалтын агуулга, төрийн албан хаагчын хөдөлмөр, нийгмийн ба тэтгэврийн даатгал, харилцааны сэтгэл зүй., 2008 оны № 1-д хүний хөгжил, төрийн алба, төрийн бус байгууллага, боловсролын бодлогын хандлага, нийгмийн бодлого, төрийн ба хувийн хэвшлийн түншлэл, улс төрийн соёлтой холбогдолтой эрдэм шинжилгээ судалгааны өгүүллүүд оржээ.

74.04/1/ /НХШУН унш-1ш/

2006. №1. -124х.

Б-22052

Б-55

2008. №1. -114х.

Б-22051

Ичинхорлоо Ш. **Сургалтын онол, хэрэглээ:** Ерөнхий дидактикийн үндэс /Хян. Л.Жамц. –УБ.: 2012. -232х.

Энэхүү гарын авлагад сургалт хэмээх ерөнхий дидактикийн гол үзэгдэл болох сургалтын тухай үзэл, онол, сургалтын зарчим, зүй тогтол, сургалтад гардаг зөрчил, сургалтын технологи, боловсролын агуулга, стандарт, сургалтын арга, хэрэглэгдэхүүн, хэлбэр, үнэлгээ зэрэг юу болох, эдгээр нь хэрхэн өөрчлөгдөж буйг авч үзжээ. Мөн түүнчлэн



боловсролын стандартын бүтэц, түүний сурган хүмүүжүүлэх зүйн үндэс, боловсролын агуулга зэргийг дэлгэрэнгүй авч үзжээ.

74.0

И-96

/НХШУН унш-3ш/

Б-21991-21992



Ичинхорлоо Ш. **Сургалтын технологи: Эрэл, хайгуул, санал, шийдэл.** –УБ.: Соёмбо принтинг, 2012. -68х.

Сургалтын технологид гарч буй өөрчлөлт, хөгжил, орчин үеийн сургалтын технологийн тухай ухагдахуун, орчин үеийн сургалтын технологийн бүтэц, сурах ба сургах арга технологи, сургалтын хэрэглэгдэхүүны төрөл агуулгын тухай энэ гарын авлагад тусгажээ.

74.202.4

И-96

Б-22014-22016

Түмэндэмбэрэл Д., Хамси Г.Ш. **Байгууллагын дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх арга зүй:** Сургалт, киноны хамт /Хян. Ц.Оюун. –УБ.: 2009. -56х.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын дизайн, ажлын төлөвлөлт, баримт бичгийн шинжилгээ, асуумж-анкет, ганцаарчилсан ба бүлгийн ярилцлага, ажиглалт, мэдээлэлд боловсруулалт хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан боловсруулах гэсэн хэсгүүдээс бүрдэх энэ номонд боловсролын байгууллагын дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээг хэрхэн хийх аргачлалыг жишээ болгон харуулжээ.

74.204

Т-78

/НХШУН унш-2ш/

Т-15921-15922



ХДХВ/ДОХ-ын халдвараас сэргийлэх талаарх Монголын боловсролын салбарын бодлогын арга хэмжээ, бэлэн байдал: Тойм судалгаа: Монгол, англи хэл дээр. –УБ.: Нээлттэй нийгэм форум, 2009. -86х.

Энэхүү судалгаа нь ЮНЕСКО-оос Монголын боловсролын салбарт хийж байгаа бодлогын дүн шинжилгээний ажлын нэгэн үр дүн бөгөөд ЮНЕСКО-ийн санхүүжилтээр төслийн хүрээнд Нээлттэй нийгэм форум ТББ тойм судалгааг эмхтгэн толилуулж байна. Мөн бодлогын арга хэмжээ нь одоо

хэрэгжиж буй ХДХВ болон ДОХ-оос сэргийлэх боловсролын бодлого, хөтөлбөрт хамаарах шалгуур бөгөөд үүнд эрүүл мэндийн албан ба албан бус сургалтын хөтөлбөрийн хүртээмж, сурах бичгийн хангамж болон чанар, багшийн хангамж зэрэг асуудлыг хамруулан авч үзжээ.

74.04

Х-82

/НХШУН унш-3ш/

Т-15923-15924

Энхтүвшин Б. **Багшлах урлаг** /Хян. З.Бат-отгон. –УБ.: 2012. -266х.



Багшлах соёл, багшийн үнэлэмж ба экологи, багшийн статус, багшийн чадвар, мастер ба маэстро багш, magna багш, багшлах ухаан, пансофи, панергеси, панартози, паннеди, багшийн авъяас хөдөлмөрийн талаар энэ номонд дэлгэрэнгүйгээр өгүүлжээ. Цэцэрлэгийн, дунд сургуулийн, ихдээд сургуулийн багш байх нь чухал биш зөвхөн та багшлах урлагийг бүрэн эзэмшсэн байх ёстой гэдэг асуудлыг энэ номонд дэвшүүлжээ.

74.204

Э-66

/НХШУН унш-7ш/

Б-22017-22019



Юра Ж. **Мэргэжлийн боловсрол, сургалтын шинэчлэлийн зарим асуудал.** –УБ.: Адмон, 2012. -231х.

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт тулгамдаж буй үндсэн асуудал бүрээр практик хэрэглээний түвшинд шийдвэрлэж болох зарим санаануудыг энэ номонд мэргэжлийн боловсрол сургалтын хөгжлийн чиг хандлага, сургалт ба ажил эрхлэлт, сургалтын агуулга, арга зүй, технологийн шинэчлэл, сургалт ба түншлэл, сургалт ба эрэлт, нийлүүлэлт, сургалтын байгууллагын удирдлага зохион байгуулалт гэсэн 6 бүлэгт хуваан авч үзжээ.

74.56

Ю-64

Т-15861-15865

СЭТГҮҮЛ ЗҮЙ

Аяако К. **XX зууны сүүлийн арваад жилийн МОНГОЛЫН НИЙГЭМ** /Ред. Г.Буянтогтох. –УБ.: Тоонотпринт, 2011. -236х.



Япон улсын Токиогийн их сургуулийн шинжлэх ухааны доктор, Монгол улсын түүхийн шинжлэх ухааны доктор, монгол судлаач Кимүра Аяако 1990 оноос шинэ мянганы эхний он жилүүд хүртэл 10 гаран жил монголд сурч, ажиллаж амьдарч байсан ажээ. Тэрээр 1993 оноос эхлэн монголын төв хэвлэлд монголын нийгмийн тухай 100 гаран өгүүлэл нийтэлж, өгүүллүүдээ “Баруунаас мандах наран-1,2,3” хэмээн 3 дэвтэрээр гаргаж байсан ба одоо түүнийгээ эмхтгэн 1 боть ном болгон толилуулж байна. Гадаадын судлаач, докторын нүдээр харсан монголын нийгэм, монголчуудын амьдралын тухай уншигч та энэ номноос уншаарай.

76.01

А-97

/НХШУН унш-3ш/

Б-22074-22075



Зулькафиль М. **Сэтгүүлчийн ур чадвар -3: Сурах бичиг** /Ред. Л.Норовсүрэн. –УБ.: Соёмбо принтинг, 2012. -297х.

“Сэтгүүлчийн ур чадвар” сурах бичгийн энэхүү 3-р дэвтэрт ямар ч онолын тодорхойлолт, тайлбар ороогүй бөгөөд зөвхөн бичих техник, арга барилын талаарх зөвлөмжийн шинжтэй зүйлүүдийг голлон оруулжээ. Өөрөөр хэлбэл залуу сэтгүүлч мэдээлэл цуглуулах, мэдээг яаж бичих, гарчиг өгөх, ярилцлага хэрхэн бичих арга зүй, өөрийнхөө үйл ажиллагааны болон нийтлэл, нэвтрүүлгийн үр нөлөөг яаж дээшлүүлэх вэ, тодорхой нэг нийтлэл, нэвтрүүлгийг ямар аргаар, яаж бичиж, бэлтгэх вэ зэргийг дэлгэрэнгүйгээр тусгажээ.

76.01я73

З-80

/НХШУН унш-7ш/

Т-15927-15929

Монгол ухаан гайхамшиг: Оюунаа тэжээхүй /Эмх. С.Оюунцэцэг. –УБ.: Мөнхийн үсэг, 2010. -184х.



Энэ номонд эрүүл ахуй, түвдэч эрдэмтэн Л.Хүрэлбаатар, сахиус залах ёс, ховордсон ургамал, Чингис хааны нэгэн зарлиг, монголчуудын хар домын эмчилгээний арга, морин зэвсгийн тулалдааны урлаг, их түүхч Далай, Чингис хааны дээдсийн сүмийн туурь, торгууд хүн, бариа засал, гэр бүлийн амьдралын ухааны талаар бичигдсэн, “Ариусахуй бясалгахуй” сонинд нийтлэгдсэн шилдэг ярилцлага, нийтлэлүүдийг эмхтгэн оруулжээ.

76.01

М-69

Б-22045-22047

МУЗЕЙ СУДЛАЛ БА БАРИМТ БИЧИГ ХӨТЛӨЛТ



Мөнхтогоо Д., Эрдмаа Д. **Музейн сан хөмрөгийн хадгалалт** /Хян. Д.Цэдмаа, Д.Бумаа. –УБ.: 2012. -86х.

АНУ-ын элчин сайдын сангийн тэтгэлгээр 2011оны 9-р сараас 2012 оны 11-р сарын хооронд Монголын үндэсний музейд “Үнэт эдлэлийн цуглуулгыг эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт төслийг хэрэгжүүлжээ. Энэ төслийн хүрээнд хэвлэгдсэн “Музейн сан хөмрөгийн хадгалалт” номонд сан хөмрөгийн зохистой орчин, цуглуулгын хадгалалтыг сайжруулах, цуглуулгатай харьцах, арчлах арга зүйн талаар өгүүлсэн ба музей судлаач, музейн ажилтан нарт энэхүү ном нь гарын авлага болох ажээ.

79.1я2

М-81

/НХШУН унш-2ш/

Т-15930-15931

Оюунчимэг Ч. **Баримт бичиг:** Онол, арга зүй /Ред. Д.Өлзийбаатар. –УБ.: 2012. -210х.



Зохиогч энэ номондоо албан хэрэг хөтлөлтийн түүхэн уламжлал, баримт бичгүүдийн талаарх ерөнхий ойлголтууд, баримт бичиг зохион бүрдүүлэхэд тавигдаж буй өнөөгийн шаардлагын талаар, удирдлагын үйл ажиллагаанд хамгийн түгээмэл хэрэглэгддэг захирамжлалын,

зохион байгуулалтын, мэдээлэл лавлагааны баримт бичгийг боловсруулах онол, арга зүйг дэлгэрэнгүй тусгасан нь албан хэрэг болон баримт бичиг боловсруулдаг хүмүүст гарын авлага болох ажээ. Мөн баримт бичгийн жишээ баримт, монгол үсгийн дүрэм, баримт бичгийн бичлэгийн алдааг засварлах тэмдгүүд, монгол кирил латин үсгийн хөрвүүлэг зэргийг номонд хавсралт болгон оруулж өгчээ.

79.3

О-63

/НХШУН унш-3ш/

T-15919-15920

ХЭЛ ШИНЖЛЭЛ, УТГА ЗОХИОЛ



Баттогтох Д. **Эсээ бичих эрдэм** /Хян. Д.Галбаатар. – УБ.: Соёмбо принтинг, 2011. -140х.


Эх хэлээрээ санаа бодлоо утга төгс, товч оновчтой, уран яруу, зөв сайхан илэрхийлж сурах, найруулан бичиж зохиох хүсэлтэй хүн бүхэнд энэхүү гарын авлага зориулагджээ. Уншигч та эсээ гэж юу вэ, үгийн учир, эсээ зохион бичлэг 2 ялгаатай юу, сургалтын эсээ, эсээ бичих төлөвлөгөө, ач холбогдол, сайн эсээ ямар байх вэ гэдэг асуултуудад хариулт аваад зогсохгүй, зарим нэг шилдэг эсээнүүдтэй танилцах болно.

80я2

Б-34

Б-22053-22056

Ловор Г., Золбаяр Л. **Монгол туургатны аман зохиолын чуулган** /Ред. Ч.Наранцэцэг, Б.Ахинбаяр. – УБ.: Сэлэнгэпресс, 2009. -364х.



Их, дээд сургууль, коллежийн оюутан, багш, судлаач нарт зориулагдсан энэ номонд монгол туургатан, манай улсын халх, дөрвөд, хотгойд, дарьганга зэрэг олон үндэстэн ястан, ОХУ-ын буриад, халимаг, БНХАУ-д орших өвөрлөгчид, Хөх нуур, Шинжааны монгол угсаатны аман бүтээлээс /зүйр цэцэн үг, оньсого, дуу, аман хууль, ерөөл, магтаал, бөөгийн яруу найраг, хүүхдийн аман зохиол, үлгэр, хууч яриа, домог, тууль, шог хошин яриа, зан үйлийн аман зохиол, ертөнцийн гурав, жүжиг/ анх удаагаа дээжлэн оруулжээ.

82.3/1/-6

Л-77

/НХШУН унш-2ш/

Т-15913-15914



Батсуурь Г. **Яруу найргийн судлал шүүмжлэлд-1:** “Дөрвөн цаг”-аас “Цаг хугацаа амсхийх...” хүртэл. – УБ.: Соёмбопринтинг, 2012. -210х.

Яруу найргийн судлал, шүүмжийн энэ номонд судлаач Г. Батсуурийн үе үеийн зохиолчид болох Д.Нацагдорж,

Б.Явуухулан, Б.Лхагвасүрэн, Д.Нямсүрэн, Д.Урианхай, Б.Галсансүх, Г.Мөнхцэцэг, Л.Өлзийтөгс, Ц.Бавуудорж, Г.Аюурзана нарын яруу найргийн зохиолуудад хийсэн утга зохиол-уран сайхны шүүмж өгүүллүүд оржээ.

83.3/1/

Б-34

/НХШУН унш-5ш/

Б-22086-22088

Ганбаатар Я. **Утга зохиолын тухай яриа:** Эрдэм шинжилгээ, шүүмж судлалын өгүүлэл, ярилцлагууд. – УБ.:2010. -337х.



Я.Ганбаатар бол монголын уран зохиолын өнөө цаг үеийн томоохон төлөөлөгч төдийгүй хуруу дарах цөөхөн судлаачийн нэг ажээ. Толилуулан буй номных нь эхний бүлэгт утга зохиолын судлалын тулгуур асуудлуудыг хөндсөн өгүүллүүд, дэд бүлэгт үе үеийн зохиолчдын бүтээл туурвилд хийсэн ажиглалт, тэмдэглэл, утга зохиолын шүүмжүүд, гутгаар бүлэгт утга зохиол, соёл түүхийн асуудлаар сонин хэвлэлд өгсөн ярилцлагуудаа эмхтгэн оруулжээ.

83.3/1/

Г-21

/НХШУН унш-5ш/

Т-15883-15885

УРАН ЗОХИОЛ



Батзориг П. **Америкт байгаа миний аавд.** –УБ.: Нэпко, 2012. -226х.

Аялагч, бие хамгаалах урлагийн тэргүүлэх зэрэгтэй тамирчин, морин спортын мастер П.Батзориг 1993, 1995 онуудад томоохон явган аялал зохион байгуулж Энэтхэг, Америкт хүрч байжээ. Тэрээр аялах замд тохиолдсон

адал сонин явдал, амь өрсөн цаг мөчүүд, хамт аялсан нөхөд, үнэнч монгол банхарынхаа тухай бичсэн өгүүлэг, тууж, аян замын тэмдэглэл, дурсамжаасаа эмхтгэн толилуулж байна.

84/1/2-4

Б-33

/НХШУН унш-3ш/

Б-21975-21976

Бөмшинь П. **Ко Сань жа**: Роман /Орч. Г.Эрдэнэчимэг. –УБ.: Мөнхийн үсэг, 2012. -303х.


БНСУ-ын утга зохиолын шагналтан зохиолч Пак Бөмшиний энэ номонд Ко Сань жа буюу Ким Жөн хогийн тухай мөн түүний “Их зүүн улсын газрын зураг” хэмээх анхны газрын зураг бүтээсэн тухай өгүүлдэг ажээ.

84/5Сол/-44

Б-65

/НХШУН унш-3ш/

Б-22096-22097



Доржготов Ц. **Энгүй тэнгэр газран далайн орон**. – УБ.: Нэлко, 2012. -456х.

Төрийн соёрхол, соёлын гавьяат зүтгэлтэн, Д.Нацагдорж, Ш.Гаадамбын нэрэмжит шагналтан Ц.Доржготов роман, тууж, өгүүллэг, хошин зохиол, нийтлэлийн 30 гаран ном бичжээ. “Энгүй тэнгэр газран далайн орон” хэмээх энэ номонд түүний сүүлийн үед бичсэн “Бурхан чөтгөр хоёр хонины бэлчээрт” тууж, өгүүллэгүүд, шог хошин зохиолууд оржээ.

84/1/2-4

Д-54


/НХШУН унш-3ш/

Б-21973-21974

ШАШИН СУДЛАЛ БА БЯСАЛГАЛ


Йогананда П. **Йогчийн намтар** /Орч. Б.Батаа. –УБ.: 2011. -280х.

“Монголын психотроникийн хүрээлэн”-гээс эрхлэн хэвлүүлсэн энэ номонд баруунд Крия-йог заасан Энэтхэгийн анхны багш Йогананда буюу Бабажи-ийн намтар түүхийн талаар өгүүлнэ.



86.42г
Й-75

Б-22048-22050



Ковалева Н. **Далд ухааны нууц**: 1,2-р дэвтэр /Орч. А.Шагдар. –УБ.: Соёмбо принтинг, 2012.

Оросын судлаач Н.Ковалевагийн туурвисан “Далд ухааны нууц” хэмээх энэхүү ном нь “Үйлийн үрийн дөрвөн зам” гэсэн нэртэйгээр 2001 онд Москвад хэвлэгджээ. Энэ номонд далд ухааны нууцыг “Зэрэгцээ ертөнц, хүний үзэгдэх язгуур чанар”, “Сэтгэлгээний матери”, “Өөр бодит чанар”, “Армагеддон”, “Үнэнд хүрэх зам” гэсэн 5 бүлэгт хуваан авч үзжээ.

86.42 1-р дэвтэр. -237х.

Б-21937-21939

К-56

2-р дэвтэр. -210х.



Б-21940-21942

Дээрхийн гэгээн ХIY Далаай лам: Шүгдэнгийн тухай
айлдвар I. – УБ.: 2012. – 144 х.

86.35

Д-97

Б-22110



Их төгсгөл ихэд гүнзгий зүрхний дуслын зэхэл хөтөлбөр Саманда бадра багшийн аман эш хэмээгч оршвой: Бүхнийг айлдагч Жигмэдчойживанбу /1808-1887/ /Төвд хэлн орч. С. Гантөмөр, Хян. А. Эрдэнэбат ба бус. – УБ.: 2009. – 400 х.

Танд өргөн барьж буй энэ ном бол Их төгсгөл ихэд гүнзгий дуслын зэхэл хөтөлбөр Саманда бадра багшийн аман эш хэмээх өнгөрсөн зуун хагасын туршид Төв Азид үлэмж нөлөө үзүүлсэн буддын шашны бүтээл юм. Агуу Нимава ёсны багш Патрул Ринбүүчий /1808-1887/ төвд хэлээр зохиосон энэхүү гайхамшигтай бүтээлийг анх удаагаа монгол хэлээр орчуулан толилуулж байна.

86.35

И-95

Б-21952-21954

Ошо. **Эзотерикийн сэтгэл зүй** /Орч. Н.Ачиймаа. – УБ.: Арвай принт, 2012. -274х.



Ошо бол орчин цагийн мистикч хүн бөгөөд түүнийг Энэтхэгийн “Сандей Мид-Дэй” хэвлэлд Энэтхэг орны хувь заяаг Махатма Ганди, Неру, Бурхан багшийн нэгэн адил өөрчилсөн арван хүний тоонд багтааж байжээ. Түүний бясалгалын аргууд нь эхлээд хүний бие махбод болон оюун ухаанд хуримтлагдсан стрессуудыг тайлж дараа нь бодолгүй байдал, бясалгалын тавирсан байдлыг мэдрүүлдэг ажээ. Тэрээр өөрөө ном бичиж байгаагүй бөгөөд түүний уншсан лекцүүдийг шавь, найз нар нь хальсан дээр буулгаж, хожим ном болгон хэвлүүлсэн нь энэ ажээ.

86.42

О-61

Б-21946-21948



Сузуки Д.Т. **Зэн буддизмын үндэс** /Орч. Б. Батаа, Хян. Б. Цэгмэд. – УБ.: 2012. – 646 х.

Сүүлийн үед зэн буддизмыг Америкт ч, Европт ч маш их эрчимтэй сонирхох болжээ.

Дорнын хамгийн эртний, гүнзгий утгатай шашнуудын нэгийг ингэж эрч хүчтэй сонирхдог болоход доктор Д.Т. Сузуки багагүй их нөлөөлжээ. Сузукигийн нилээд хэдэн бүтээлийг өрнөдийн олон хэлнээ хөрвүүлсэн байдаг. Англи хэлээр хэвлэн гаргасан бүтээлүүдийнх нь тоонд “Зэн буддизмын оршил”, “Зэн амьдрал”, “Зэн буддизмын гарын авлага”/сурах бичиг/, “Зэн буддизм”, “Христийн болон буддын шашин дахь агийн ёс”, “Зэн буддизмын тухай өгүүлүүд, гурван цуврал”, “Ланкаватара-судар”, “Зэн ба японы соёл”, “Зэн буддизмын мөн чанар” зэрэг бусад олон бүтээлүүд нь багтдаг.


86.2

С-70

Б-21988-21990

Сүхбат Ш. **Монбуддизм** /Хян. Ш. Нарантуяа. – УБ.: Мөнх дардас, 2011. – 118 х.


Шашин бол бодит амьдралаас батлагдан, туршигдаж үүссэн хүний амьдрах арга замын хэсэг юм. Шашныг хүн бүтээгээгүй харин үүсгэснийг урт удаан хугацааны



туршилт нотолгооны үр дүнд бүтээгдэжээ. Өнөөгийн манай хүмүүсийн шашны талаарх мэдлэг боловсрол үнэхээр дулимаг байгаа нь цаашид хандах тэдний хандлагын илэрхийлэл болж байгаагийн зэрэгцээгээр мухар сүсэгт баригдах явдал байсаар. Иймээс энэхүү номыг шашны талаарх мэдлэгтээ нэмэрлэхэд тань туслах болно.

86.3
С-86

Б-21955



Сүхбат Ш. Монгол бөөгийн дэлгэрэнгүй толь-III
/Хян. Ж. Мятагмаа. – УБ.: Бишрэлт тэнгэр, 2012. – 408 х.

Энэхүү толь дотор бөөгийн шүтлэгийн дотоод агуулгыг нээж болох олон тооны үг хэллэгийн утга агуулгыг тайлбарлажээ. Монгол судлал, монгол ёс зүй, угсаатны зүй, түүх, шашин шүтлэгийн өргөн дэвсгэр дээр анх удаагаа монгол бөөгийн холбогдолтой хэсгийг энэ тольд оруулж өгчээ.

86.33я2

С-86

/НХШУН унш-3ш/


Т-15895-15897

Шри Чинмой. Шри Чинмой багшийн төгс мэргэн сургаал. – УБ.: 2000. – 528 х.

86.42

Ш-84

Б-22036-22038



Философи, сэтгэл зүй



Волф Ж. Улс төрийн философи /Орч. Б. Батчулуун, Хян. Ц. Сумъяа, Ред. Х. Дондог. – УБ.: Нэпко, 2012. – 233 х.

Энэхүү номонд улс төрийн философийн хамгийн гол асуудлуудаарх эртний Грекээс аваад өнөөг хүртэл хэлэлцэж буй маргаануудыг авч үзэн хамгийн хүчтэй хариултуудыг судлажээ. Номны эхний таван бүлэг байгалийн захиргаа, төр ардчилал, эрх чөлөө, өмч гэсэн сэдвүүдийг танилцуулж, сүүлчийн бүлэгт нь эмэгтэйчүүдийн эрхийн тухай

орчин үеийн улс төрийн онолын зарим баримтлалыг авч үзсэн болно.

87

В-67

/НХШУН унш-7ш/


Б-21998-22000

Томпсон М. **Философи**:Өөрөө сурах бичиг /Орч. Б. Батчулуун, Ред. Ц. Сумъяа. – УБ.: Нэпко, 2012. – 220 х.

87

Т-48 /НХШУН унш-7ш/

Б-21993-21995



Друнвало М. **Амьдралын цэцэгийн эртний нууц: Боть-II** /Орч. Г. Бат-Эрдэнэ, Хян. Д. Цэрэндулам. – УБ.: 2012. – 786 х.

Друнвало 1985 оноос 1994 он хүртэл “Амьдралын цэцэг” семинарыг олон улсад илтгэн танилцуулсан билээ. Энэхүү номыг 1993 оны 10-р сард Айова мужийн Фэйрфийлд хотод болсон 3-р албан ёсны бичлэг хийсэн семинараас сэдэвчлэн нийтэлжээ. Друнвало олон жилийн туршид өөрийн цаглашгүй үзэхүйгээ орчлон дэлхийд “Амьдралын цэцэг” программ-семинар болон Мер-Ка-Ба бясалгалаар дамжуулан өгч байна. Энэ сургаал хүний мэдлэгийн бүх хүрээг хамардаг, хүн төрөлхтний хөгжлийг хамгийн эртний иргэншлээс өнөөг хүртэл хамран үздэг бөгөөд дэлхийн ухамсрын байдлын талаар 21 зуунд аажим, хөнгөн шилжиж орохын тулд юу хэрэгтэй юм бэ гэдэгт тод ойлголт өгдөг.


88.2

Д-76

Т-15910-15912

Сэтгэл зүйн фитнесс: Хоёрдахь хэвлэл. – УБ.: 2012. – 166 х.

Сэтгэл зүйн фитнесс буюу сэтгэл зүйгээ дасгалжуулна гэдэг нь өөрийнхөө амьдралыг зөв дүгнэж, зөвхөн өөрт байгаа дотоод болон гадаад нөөц боломж, авьяас, чадвараа бодитоор үнэлж, өөрийгөө байгаагаар




нь хүлээн авч, өөрөөсөө мэдсэн бүхнээ цааш улам хөгжүүлж, нэг ёсондоо сэтгэл хангалуун амьдрахдаа сурсан мэдсэнээ ашиглана гэсэн үг. Тэгвэл та энэ номыг уншиснаар нөөц бололцоондоо тулгуурлан өөрийгөө шинээр нээж хүссэн үр дүндээ хүрнэ.

88.52

C-97

Б-22032-22035



Шанкар. **Шинэ мянганы мэргэн ухаан:2** дахь хэвлэл /Орч. П. Баяр, Хян. В. Алтанцэцэг. – УБ.: Адмон, 2009. – 167 х.


Дэлхийн 3 ухаантны нэг болох дээрхийн гэгээн Шри Шри Рави Шанкарын шилмэл бүтээлүүдийн нэг энэ ном юм. Шанкар нь амьдрах урлаг сангийн үүсгэн байгуулагч бөгөөд дэлхий даяар аялан агуу оюун ухааны уламжлалууд нь нийтлэг зорилго, үнэт зүйлстэй болохыг сануулан хичээлээ заадаг. Түүний хайр, бодит мэргэн ухаан, нигүүслийн энгийн үгс нь амьдралын алхам тутамд хүмүүсийг уриалан дуудсаар байдаг. Тэрбээр хүн бүрт сонгосон үнэн мөнийн зам, зан заншлаа даган явахдаа бусдын замыг хүндлэх урам зориг өгдөг байна. Түүний мэдлэг, хөтөлбөрүүд нь дэлхий дахинд хүмүүсийн стрессийг багасгах, бие мах бод болон сэтгэлээ эмчлэхэд болон бие биеэндээ хамааралтай болох мэдрэхүйг хөгжүүлэхэд тусласаар иржээ.

88.6

Ш-84

Б-22039-22041

Эскивель Л. **Мэдрэмжийн тухай ном** /Орч. Б. Оюунчимэг, Ред. О. Мягмар. – УБ.: 2010. – 64 х.



Зохиогч Лаура Эскивель хүний бие бялдар, оюун санааны хувьд эрүүл саруул бодгаль хийгээд нийгмийн сэтгэл хөдлөлийн үүсэл хөгжил, мөн чанар, ач холбогдлын талаар гайхалтай энгийн бөгөөд яруу тодоор энэхүү номондоо өгүүлэх ажээ.

88.3

Э-84

Б-21958-21960